



# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.03. №67 (67)

ҮЙЛ ЯВДАЛ

## Дэд хурандаа Д.Гройне: “МАРМАЛ” БААЗЫН ХАМГИЙН ШИЛДГҮҮД НЬ МОНГОЛ ЦЭРГҮҮД БИЛЭЭТ



ИБНАУ-д явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд ХБНГУ-тай хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын XIII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнд Умард Атлантын гэрээний байгууллагын медаль гардуулах ёслолын арга хэмжээ боллоо. Арга хэмжээнд “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагааны Хойд бүсийн командлагч, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний бригадын генерал А.Майер, “Мармал” баазын хүчлэн хамгаалалтын батальоны захирагч, дэд хурандаа Д.Гройне нар болон олон улсын цэргийн үндэсний ахлах төлөөлөгчид урилгаар оролцлоо.

Дэд хурандаа Д.Гройне Монгол Улсын XIII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнд хандаж “Эрхэм журмын нөхдөдөө энэ өдрийн мэнд хүргэе.

Мазар-И-Шарифын командлал буюу хуучнаар Хойд бүсийн цэргийн командлалын далбаа буулгах ёслол болж өнгөрсөн хэдий ч Монгол Улсын XIII ээлжийн цэргийн багийн захирагч бид хоёр ярилцаад Монголын цэргийн багт медаль гардуулах арга хэмжээг зохион байгуулж байгаа билээ. Өнөөдрийн үйл ажиллагаа нь Монголын цэргийн багийн үүрэг гүйцэтгэлт дуусаж байгаа хэрэг биш та бүхний үүрэг гүйцэтгэлтийг өндрөөр үнэлэн зохион байгуулж буй арга хэмжээ юм.” гээд 2009 оноос өнөөг хүртэл хамтран үүрэг гүйцэтгэх хугацаанд ажиллагааны зорилго, гүйцэтгэх үүрэгт ямар ч өөрчлөлт орсон Монгол цэргүүд оногдсон үүргээ амжилттай гүйцэтгэж ирсэн гэдгийг онцлон “Энд зогсож байгаа та бүхэнд болон энд үүрэг гүйцэтгэж байсан үе

үеийн Монгол Улсын цэргийн алба хаагчдад баярлаж бахархаж байгаагаа илэрхийлье” гэсэн юм.

Мөн тэрээр баазын нэгдсэн дадлагуудаар Монгол цэргүүд өндөр түвшинд бэлтгэгдсэн, ямар ч цагийн байдалд үүрэг гүйцэтгэх чадвартайгаа батлан харуулж, сахилга бат, үнэнч байдал, мэргэжлийн ур чадвараараа “Мармал” баазын үлгэр жишээ цэргийн баг байсаар ирснийг цохон тэмдэглэж, цэргийн багийн захирагч, дэд хурандаа Э.Амартүвшинд талархал, цэргийн алба хаагчдын төлөөлөл болгож, 10 офицер, ахлагчид Умард Атлантын гэрээний байгууллагын медалийг гардуулан өгсөн юм.

Ахлах дэслэгч П.Отгонбаатар

## СЕРГЕЙ ЛАВРОВ Ж.ГҮРРАГЧААД АЛЕКСАНДР НЕВСКИЙН ОДОН ГАРДУУЛЛАА

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин гуравдугаар сарын 15-ны өдөр Монголын сансрын нисэгч, “Монгол, Оросын найрамдлын нийгэмлэг”-ийн тэргүүн Ж.Гүррагчааг ОХУ, Монголын бүх талын стратегийн түншлэлийг хөгжүүлэх, ард түмний найрамдлыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмэр, гавьяаг нь үнэлэн Александр Невскийн одонгоор шагнасан билээ.

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимиры зарлигт “ОХУ болон Монгол Улсын хоорондын иж бүрэн түншлэлийг хөгжүүлэхэд гавьяа байгуулсных нь төлөө Монгол Улсын иргэн, Монгол-Оросын найрамдлын нийгэмлэгийн Ерөнхийлөгч Жүгдэрдэмидийн Гүррагчааг Александр Невскийн одонгоор шагнасугай” гэжээ.

Тус одонг ОХУ-ын ГХЯ-ны сайд Сергей Лавров тус шагналыг 6 дугаар сарын 1-ний өдөр Москва хотноо гардуулан өглөө.

Тэрээр “Ерөнхийлөгч В.Путины даалгавраар Монголын ард түмний агуу хүү, Оросын ард түмний анд нөхөр Ж.Гүррагчаад Александр Невскийн одон гардуулан өгч байгаадаа их баяртай байна” гэж ёслолын үеэр хэллээ.

Жүгдэрдэмидийн Гүррагчаа нь сансарт ниссэн Ази тивийн 2 дахь, дэлхийн 101 дэх хүн бөгөөд ОХУ-ын төрийн шагнал Александр Невскийн одонгоор шагнагдсан анхны Монгол иргэн боллоо.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

60.372

ЭДГЭРСЭН

51.448

НАС БАРСАН

286/3

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2602 (35)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

261

ЭДГЭРСЭН

2304

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 172,405,182

Эдгэрсэн

Нийт: 155,035,947

Нас барсан

Нийт: 3,705,943

## ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

13,819 3,182,775

ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

7,102 2,955,253

ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

1,516 431,195

ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН

СҮҮЛИЙН 24 ЦАГТ НИЙТ

482 84,433

2021.06.02

11:00 ЦАГИЙН БАЙДАЛ



ЦАХИМ ШУУДАНД

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНТ ХОРОО

Зэвсэгт хүчний 065 дугаар анги



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 065 дугаар анги орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан төрийн одон, медаль гардуулах, цэргийн алба хаасны тэтгэвэрт гарч

байгаа офицер, ахлагч нар Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг зохион байгуулж явууллаа. Уг арга хэмжээнд Агаарын цэргийн Командлагч хошууч генерал О.Энхбаяр тэргүүтэй албаны хүмүүс мөн Цэргийн гавьяаны одон авах хүртэлх түүхийг бүтээлцсэн чадварлаг үе үеийн захирагч, штабын дарга нар, мөн энэ онд цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан алба хаагч нар оролцлоо.

**Ахмад Ө.ЭНХСАРУУЛ**

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ЧӨЛӨӨТ ЦАГИЙГ ЗӨВ БОЛОВСОН ӨНГӨРҮҮЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 186 дугаар анги



Хугацаат цэргийн алба хаагчдын дунд баяр амралтын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний дагуу

буй үйл явдлын талаар мэдээлэл хийн, саадын зурвасыг туулах, хөгжөөнт буухиа, нормативын буухиа тэмцээнүүдийг зохион байгуулж, “Эх орны төлөө” нэвтрүүлгийг үзүүлээ.

Эх үрсийн баярыг тохиолдуулан соёлын төвийн дарга ахмад Э.Ганбаяр, МАБ-ын офицерын дэслэгч Д.Одончулуун нар хугацаат цэргийн алба хаагчдыг ар гэртэй нь холбоо бариулах ажлыг зохион байгуулсан. Мөн байнгын бие бүрэлдэхүүнээс өрх толгойлсон офицер, ахлагч нарын хүүхдүүдэд эх үрсийн баярыг тохиолдуулан гарын бэлгийг гардуулан, баяр дээр баяр нэмлээ.

## АМЖИЛТ ХҮСЬЕ!

Алдар түүхт Ховдын хороо, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамц Ховд хотоос Улаанбаатар хот хүртэл 1500 километр замыг гүйж туулахаар зориг шулуудан өчигдөр гараанаасаа гарлаа.


Түүнийг Ховд аймгийн удирдлага болон ангийн удирдлагууд ёслол төгөлдөр гарган өгч амжилт хүслээ.

Тэрээр 2020 оны 7 дугаар сард ИБНАУ-д явагдаж байгаа “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд үүрэг гүйцэтгээд эх орондоо иржээ. Эх орондоо ирээд цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан тусгаарлагдаж байх үедээ “Цэргийн алба хаагч яагаад холын зайд гүйж болохгүй гэж” бодоод зорилгоо болгосон байна. Өнгөрсөн хоёрдугаар сараас эхлэн холын зайд гүйх сэтгэл зүй, бие бялдраа бэлтгэж эхэлсэн бөгөөд өдөрт 10 км, 10 хоногийн дараа 20, 20 хоногийн дараа 45-50 км болгож нэмэгдүүлсэн байна.

Түүний бэлтгэл бүрэн хангагдаж, ямар ч зовуургүй, амьсгаа задарч, ядралгүй болсныхоо дараа ангийнхаа удирдлагад Ховд аймгаас Улаанбаатар хот хүртэлх гүйх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ.

Ховд аймгаас Улаанбаатар аймаг хүртэлх зай 1500 км. Өдөрт 45-50 км гүйнэ. Ингэхдээ өглөөд 25 км, үдээс хойш 25 км гүйнэ гэж тооцоолсон байна.

Гэхдээ цагагаарын нөхцөл байдлаас хамаараад энэ тоо бага зэрэг өөрчлөгдөхийг



гүйсгэхгүй гэнэ.

Өдөрт 45-50 км гэж тооцооор 40 орчим хоног тасралтгүй гүйж, 7 дугаар сарын 10-нд “Төрийн далбааны өдөр”-ийн цэргийн ёслолын жагсаалын дараахан жанжин Д.Сүхбаатарын талбайд ирэхээр төлөвлөжээ.

Сонирхуулахад түүнд туслаж, дэмжлэг үзүүлэх эмч, тогооч нарын баг хамт явж байгаа бөгөөд тэд автомашинаар явах юм. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийхээ нэрийн өмнөөс ахлах ахлагч Э.Даваажамцдаа амжилт хүсье!

## “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 232 дугаар анги



“Олон улсын хүүхдийн хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Аз жаргалтай гэр бүл” өдөрлөгийг халдвар хамгааллын дэглэмийг

баримтлан зохион байгуулж явууллаа. Өдөрлөгөөр офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын гэр бүлд хэсэгчилсэн урлагийн тоглолт толилуулж, 1

хүртэлх насны ангилалд “Азын бөмбөлөг”, 2-4 насны ангилалд “Гар зургийн уралдаан”, 5-7 насны ангилалд “Унадаг дугуй унах”, 8-12 насны ангилалд “Даам”, 13-16 насны ангилалд “Авьаас” тэмцээн ийг явуулав. Мөн алба хаагчдынхаа гэр бүлийн дунд “Аз жаргалтай гэр бүл” буухиа, “Супер ээж” тэмцээнийг тус тус амжилттай зохион байгуулж, оролцсон нийт багачууддаа ангийн удирдлагууд гарын бэлэг гардуулан өглөө.

## “РАГЧАА САН”-ЫН НЭРЭМЖИТ ШИЛДЭГ ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ТОДОРЛОО

Зэвсэгт хүчний 311 дүгээр анги

Олон улсын энхийг сахиулагчдын баярын өдрийг тохиолдуулан хошууч генерал Гүрийн Рагчаа агсны дурсгалын хөшөөнд цэцэг өргөх ёслолын ажиллагаа болон баярын хүндэтгэлийн цуглааны арга хэмжээ зохион байгуулагдаж өнгөрлөө. Тус арга хэмжээнд тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, Батлан

хамгаалах яамны гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, хошууч генерал Г.Рагчаа агсны гэр бүл болон албаны бусад хүмүүс байлцлаа. Ёслолын арга хэмжээнд ангийн захирагч, хурандаа Ц.Буянжаргал, Б.Бат-Эрдэнэ нар энхийг сахиулагчдын загалмайлсан эцэг хошууч хэмээдэг хошууч генерал Г.Рагчаа

агсны үйл хэрэг, түүхэн замналыг хүндэтгэн дурдаж, энхийг сахиулагч цэнхэр дуулгалан цэргүүдийн яруу алдрыг бахархан үг хэллээ. Мөн энэ арга хэмжээнд “Рагчаа сан”-ын нэрэмжит шилдэг энхийг сахиулагчдад олгодог дурсгалыг хошууч н. Зулзаяа, ахмадн. Пүрэвсүрэн, ахлах ахлагч н.Эрдэнэгэрэл нарт гардуулан өглөө.

## ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭМЭГТЭЙЧҮҮД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 167 дугаар анги



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс өрх толгойлсон эмэгтэйчүүд болон гурван хүүхдэд сэтгэлийн бэлэг гардууллаа. Энхрий үрс минь инээд баяслаар бялхаж Эрүүл саруул аз жаргалтай байх болтугай.

**Дэслэгч Г.НАНДИНЧИМЭГ**

## ХҮҮХЭД БҮХЭН ИНЭЭЖ БАЙГ, САЙХАН БАЯРЛААРАЙ

Зэвсэгт хүчний 186 дугаар анги



Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ангийн байнгын бүрэлдэхүүний 2-5 насны хүүхдүүдэд цар тахлын халдвар хамгааллыг сахиулан, аав, ээжүүдэд нь гарын бэлгийг нь өгч баярлууллаа. Тус бэлэгтэй хамт “Хүүхэд бүхэн инээж байг. Сайхан баярлаарай” хэмээсэн ангийн захирагчийн үеийг хамтатгав.

Мөн тус ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд “Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг Биеийн тамир спортын офицер, ахлах ахлагч Ч. Бархүү амжилттай зохион байгуулан явууллаа. Тэмцээний 1 дүгээр байрт Танкийн ротын баг, 2 дугаар байрт Гаубицын артиллерийн батареины баг, 3 дугаар байрт Тийрэлтэт артиллерийн батареины багууд тус тус шагналт байрыг эзэллээ.